

ТАНИЛЦУУЛГА

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл
гомдлын шийдвэрлэлтийн тухай

/2023 оны хагас жилийн байдлаар/

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2023 оны хагас жилийн байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн танилцуулж байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 8141 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 7883 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 94,7 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 258 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна. Мөн тус онд өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой өвс, тэжээлийн дэмжлэг хүссэн хүсэлт 963 ирсэн нь нийт өргөдлийн 11,8 хувийг эзэлж байна

2023 оны хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргад хандаж 69 өргөдөл, гомдол ирснээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин ирсэн 25 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн.

Аймгийн нийт төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгдүгээр, өргөдлийг ирүүлсэн хэлбэрээр нь ангилан хоёрдугаар, нийт өргөдлийн агуулга болон зонхилж байгаа асуудлыг гуравдугаар хавсралтаар тус тус харуулав.

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн нэгдүгээр хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан
тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын
шийдвэрлэлтийн байдал

/2023 оны хагас жилийн байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн хувь
1	Аймгийн ЗДТГ	69	62	-	-	7	89,9
2	Агентлаг	4869	4674	-	-	195	96,0
3	Сумд	3203	3147	-	-	56	98,2
	ДҮН	8141	7883	-	-	258	94,7

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн хоёрдугаар хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл
гомдол, санал хүсэлт /хэлбэрээр/

/2023 оны хагас жилийн байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ЗДТГ	69	44	25	-	-	-
2	Агентлаг	4869	4491	132	7	239	-
3	Сумд	3203	2046	281	401	475	-
	Дүн	8141	6581	438	408	714	-

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн гуравдугаар хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан
тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол,
санал хүсэлтийн агуулга /Хувиар/

/2023 оны хагас жилийн байдлаар/

1	Сүхбаатар аймаг	Нийт 8141 өргөдөл, гомдол, хүсэлт, талархал ирснээс: 1. Өргөдөл, хүсэлт –7942 2. Санал - 123 3. Гомдол - 62 4. Талархал - 14		
		1. Хөдөлмөр халамж үйлчилгээний асуудлаар	3439	42,2
		2. Өвс тэжээл хүссэн хүсэлт	963	11,8
		3. Газрын асуудлаар	475	5,8
		4. Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлаар	335	4,1
		5. Нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар	315	3,8
		6. Стандарт хэмжил зүйтэй холбоотой	219	2,6
		7. Шагнуулах хүсэлт	175	2,1
		8. Татвартай холбоотой	142	1,7
		9. Байгаль орчинтой холбоотой	136	1,6
		10. Гэр орон байр хүссэн	118	1,4
		11. Буцалтгүй тусламж мөнгөн дэмжлэг хүссэн	114	1,4
		12. Цаг үеийн асуудлаар	108	1,3
		13. Улсын бүртгэлтэй холбоотой	56	0,6
		14. Бусад асуудлаар	1546	18,9
НИЙТ - 8141				

